



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/51

Номгон

“Төрийн архивын баримтыг иж бүрэн нягтлан шалгах” хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 тогтоолоор батлагдсан аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хавсралтын 20 дугаар заалт, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Аймгийн Засаг даргын 2007 оны 11 дүгээр сарын 14-ний “Төрийн архивын баримтыг иж бүрэн нягтлан шалгах” дэд хөтөлбөр баталсан 427 дугаар захирамжийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.“Төрийн архивын баримтыг иж бүрэн нягтлан шалгах” хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Иж бүрэн нягтлан шалгах болон сэлбэн засалтын үйл ажиллагаанд 3,0 сая (Гурван сая) төгрөгийг Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөг хэрэгжүүлж, хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг Архивын тасаг (В.Эрдэнэчимэг)-т, дагаж мөрдөж ажиллахыг нийт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310125